



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/018/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 497

танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Засаг даргын харьяаны сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд холбогдох 9,400.0 мянган төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн санд холбогдох 29,054.0 мянган төгрөгийн, Аварга тохижилт ОНӨААТҮГ-т холбогдох 440.0 мянган төгрөгийн, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хамаарах 375,689.1 мянган төгрөгийн, нийт 414,583.1 мянган төгрөгийн 7 зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөд үндсэн үйл ажиллагааны зардлаас 9,400.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгож батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- Орон нутгийн хөгжлийн сангаас гамшигаас хамгаалах агуулахын байр барих ажилд 29,054.0 мянган төгрөгийн урьдчилгааг гэрээ зөрчин олгосон,
- Аварга тохижилт ОНӨААТҮГ түрээсийн орлогын 40 хувь болох 440.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй,
- Төсвийн төвлөрүүлэн захирагч орон нутгийн ерөнхий орлогын урьд оны үлдэгдлээс 33,972.0 мянган төгрөгийг бүрэн төлөвлөөгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн 52

зээлдэгчийн 238,798.6 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй, батлагдсан төсвийн орлогыг 102,918.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Энэ нь дараах хууль тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",
- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.4. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах",
- ✓ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2. Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийх, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах",
- ✓ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралт Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.4.5. "зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх" 7.3. "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна"
- ✓ Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ" гэснийг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн төсвөөс 429,831.6 мянган төгрөгийн дэмжлэг авч, 1,005,983.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 2,180,747.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 347,664.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 52,598.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 49,752.4 мянган төгрөгийг зарцуулж, 2,845.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитаар сумын хэмжээнд нийт 1,019,709.1 төгрөгийн 20 алдаа, зөрчил илэрснээс 570,298.4 мянган төгрөгийн 13 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 440.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 72,426.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 341,717.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар сарын 19-ны хуралдааны 22 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 90.9 хувь, "үр дүн гарсан" гэж дүгнэсэн байна.

Дэлгэрхаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь үндэслэлгүй шийдвэр гаргаж Аварга тохижилт ОНӨААТҮГ-ын удирдлагыг томилохыг Аварга багийн засаг даргад даалгасны дагуу Аварга багийн Засаг дарга нь Аварга тохижилт ОНӨААТҮГ-ын газрын даргыг үндэслэлгүй томилон ажиллуулсан нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.6. тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх, 35.1.15.Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 22.Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 2/ орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;" гэснийг зөрчсөн тул 1 албан шаардлага хүргүүлээ.

Орон нутгийн хөгжлийн сангаар 384,493.1 мянган төгрөгийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4 ажлыг 304,528.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлж, 1 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Сумын төсвийн орлого зарлагыг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэгжүүлэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэм үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,573,317.96	1,030,136.7
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,059,125.83	643,249.45
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	262,162.69	245,505.92
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	252,029.44	141,381.33
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,033,788.16	1,453,449.03
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,033,788.16	1,453,449.03
7	1.2.2.02 Биет хөрөнгө		970,870.12	1,327,946.19
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	62,918.04	125,502.84
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		2,607,106.12	2,483,585.73
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,359.85	153,569.71
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		2,359.85	153,569.71
12	2.1.1.03 Өглөг		1,226.4	147,719.71
13	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,133.45	5,850
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,604,746.27	2,330,016.01
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		2,604,746.27	2,330,016.01
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		392,590.91	455,175.71
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		2,112,013.2	1,776,330.87
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		100,142.16	98,509.43
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		2,607,106.12	2,483,585.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,597,659.31	1,873,963.06
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		919,155.1	990,656.24
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		728,164.94	716,584.04
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		728,164.94	716,584.04
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		27,129.65	37,449.44
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		163,860.51	236,622.76
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	334,861.6	883,306.82
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	479,297.87
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,343,642.61	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,744,941.26	2,200,320.92

11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,744,941.26	2,200,320.92
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,715,776.03	2,191,165.06
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		715,839.52	911,455
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		86,060.08	101,022.31
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		409,690.85	442,441.79
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		47,737.06	96,005.75
17	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		37,701.28	59,965.9
18	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		20,022	41,230
19	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		157,448.78	242,608.1
20	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		241,276.47	296,436.22
21	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		29,165.24	9,155.86
22	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		852,718.05	-326,357.86
23	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		260,765.41	10,957.2
24	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-260,765.41	-10,957.2
25	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		591,952.64	-337,315.06

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,339,324.15	1,844,804.53
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	919,155.1	990,656.24
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	728,164.94	716,584.04
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	27,129.65	37,449.44
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	163,860.51	236,622.76
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,592.03	22,471.53
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	70,449.13	74,584.7
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	86,819.35	139,566.52
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,526.44	854,148.29
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	76,526.44	131,545.04
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	482,429.66
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	240,173.6
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,343,642.61	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,578,668.05	1,909,064.39
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,578,668.05	1,909,064.39
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,546,645.55	1,896,854.73
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	711,358.7	906,964.06

18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,209.46	100,846.71
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	409,690.85	442,441.79
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	44,882.83	51,573.92
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	305.8	4,137
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	41,161.08	51,535
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	20,022	41,230
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,403.62	253,709.22
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	68,611.22	44,417.04
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,022.51	12,209.66
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	760,656.1	-64,259.85
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	359,454.49	351,466.53
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	359,454.49	351,466.53
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	359,454.49	351,466.53
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-359,454.49	-351,466.53
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150	150
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-150	-150
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	401,051.61	-415,876.39
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	658,074.23	1,059,125.83
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,059,125.83	643,249.45

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,012,793.63		2,012,793.63
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,012,793.63		2,012,793.63
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	591,952.64		591,952.64
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,604,746.27		2,604,746.27
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,604,746.27		2,604,746.27
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,632.74		1,632.74
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,606,379.01		2,606,379.01
8	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,632.74		-1,632.74

9	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	62,584.8		62,584.8
10	1.7 Тайлант үеийн үр дүн	-337,315.06		-337,315.06
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,330,016.01		2,330,016.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,986,476.8	2,680,150.0
11	3.1.01.1.1 Татварын орлого	873,070.0	990,656.2
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	659,800.0	716,584.0
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	659,800.0	716,584.0
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	584,300.0	637,429.2
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	54,000.0	47,678.3
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	20,000.0	30,587.8
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,500.0	888.6
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	68,400.0	37,449.4
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	20,800.0	15,040.0
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	600.0	600.0
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	47,000.0	21,809.5
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	144,870.0	236,622.8
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,600.0	22,471.5
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгийн хураамж	2,000.0	6,888.4
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	600.0	670.0
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0	14,913.2
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	65,000.0	74,584.7
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	65,000.0	74,584.7
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	71,270.0	139,566.5
118201	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	4,870.0	4,549.3
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	54,400.0	117,163.3
118203	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	12,000.0	17,854.0
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	2,113,406.8	1,689,493.8
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	85,500.0	30,784.3
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	8,000.0	10,737.0
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	75,000.0	11,446.4
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	2,500.0	4,010.9
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	-	4,590.0
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,787,733.2	1,418,535.9
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	429,831.6	429,831.6
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	1,357,901.6	988,704.3
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	240,173.6	240,173.6
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	240,173.6	240,173.6
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,697,384.6	3,957,887.5
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,159,780.3	3,653,209.5
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,143,268.3	1,808,762.4
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	973,956.8	867,573.4
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	378,148.8	364,763.6
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	369,242.4	325,369.0

210103	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	27,720.0	20,825.2
210104	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	74,804.0	49,155.2
210105	3.1.01.2.1.1.1.05	Гэрээт ажлын хөлс	124,041.6	107,460.5
2102	3.1.01.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,744.7	100,846.7
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	82,786.4	70,068.5
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	9,739.5	8,537.0
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	4,869.8	4,250.0
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	4,869.8	3,587.8
210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	19,479.2	14,403.4
2103	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	486,333.0	438,595.4
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	88,412.9	62,936.3
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	393,194.1	371,048.2
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	4,726.0	4,610.9
2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	46,373.5	28,490.6
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	5,874.1	3,220.1
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	27,294.0	18,565.8
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,588.4	3,413.4
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	2,063.2	1,007.8
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,553.8	2,283.5
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	7,807.1	4,137.0
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,807.1	4,137.0
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	63,463.7	54,571.0
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	7,520.6	3,036.0
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.1	-
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	55,000.0	51,535.0
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	55,089.0	41,230.0
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	55,089.0	41,230.0
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	318,539.1	232,574.9
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	278,432.2	196,032.4
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.7	-
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	1,014.3	-
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	536.4	288.3
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.6	121.0
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,595.4	1,342.0
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	35,753.5	34,791.2
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	69,961.4	40,743.4
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	57,539.4	33,327.8
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,422.0	7,415.6
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,512.0	1,844,447.0
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,835,083.0
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	1,835,083.0
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	16,512.0	9,364.0
213208	3.1.01.2.1.4.2.07	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,512.0	8,878.5
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000.0	485.5
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	384,493.1	304,528.0
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	384,493.1	304,528.0
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	153,111.2	150.0
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	153,111.2	150.0
8	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	289,092.2	- 1,277,737.5
9	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 289,092.2	1,277,737.5
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 289,092.2	1,277,737.5

4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,055,781.4
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	624,422.6
6	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	52	50
61	6.1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	6.1.01	Төсвийн байгууллага	2	2
62	6.2	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	24
620001	6.2.01	Удирдах ажилтан	7	7
620002	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	9	8
620003	6.2.03	Үйлчлэх ажилтан	5	5
620004	6.2.04	Гэрээт ажилтан	4	4
65	6.5	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	24
650001	6.5.01	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	9
650009	6.5.09	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650011	6.5.11	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	52,598.1
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,598.1
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	52,598.1
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	52,598.1
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	52,598.1
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,641.1
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,957.0
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,752.4
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	6,377.9
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,377.9
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	2,803.9
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	300.0
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	2,293.9
210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210.0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,074.0
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,074.0
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	2,500.0
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	2,225.0
210902	1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	275.0
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,374.5
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	43,374.5
223001	1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө	43,374.5
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,845.6

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан, Аварга тохижилт ОНӨҮГ-ын нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аймаг дахь Төрийн аудитын газар ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Платиниум прогресс аудит ХХК Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль аудитын түүвэрт хамрагдсан болно.

3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 616,279.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 565,769.5 мянган төгрөгийн 12 залруулга, 38,454.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 440.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 565,769.5 мянган төгрөгийн 12 алдаа¹г санхүүгийн тайланд аудитын явцад залруулсан. Үүнд:

ЗДТГ: Төсвөөс олгосон санхүүжилтийн орлого, төсөвт төвлөрүүлсэн үлдэгдлийг 3,971.3 төгрөгөөр илүү тусгасан, шинээр бүртгэсэн 62,584.8 мянган төгрөгийн 8 газрыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн алдааг залруулав.

ИТХ: Санхүүгийн тайланд санхүүжилтийн орлого, төвлөрүүлсэн шилжүүлгийг 7,270.8 мянган төгрөгөөр илүү тусгасныг залруулав.

ОНХС: Санхүүгийн тайланд гамшгаас хамгаалах агуулахын байр, халуун ус саун, фитнесийн байр барих ажлын гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 109,035.7 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй, тайлант оны ажлын дутуу санхүүжилт 22,857.3 мянган төгрөгийг хасах үлдэгдэлтэйгээр илэрхийлсэн алдааг залруулсан.

Аварга тохижилт ОНӨҮГ: Санхүүгийн тайланд ОНХС-аар хэрэгжүүлсэн 328,011.1 мянган төгрөгийн, худалдан авсан 528.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй, хуримтлагдсан үр дүн дансыг 1,296.4 мянган төгрөгөөр зөрүүтэй, татварын өглөгийг 6,993.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн 5 алдаа илэрснийг залруулав.

Төлбөрийн акт:

1. Аварга тохижилт ОНӨҮГ нь халуун ус,саун, фитнесийн барилгыг түрээслүүлсний орлогын 40 хувь 440.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага:

1. ИТХ нь сумын ИТХ-ын төлөөлөгчдөд үндсэн үйл ажиллагааны зардлаас 9,400.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгож батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан. зөрчилд албан шаардлага хүргүүлэв.
2. ОНХС-аас гамшигаас хамгаалах агуулахын байр барих ажил гүйцэтгэх гэрээг зөрчин анхан шатны баримтын бүрдэлгүй 29,054.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2. Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 380,218.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 4,528.9 мянган төгрөгийн 1 залруулга, 33,972.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 341,717.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,528.9 мянган төгрөгийн 1 алдаа²г санхүүгийн тайланд аудитын явцад залруулсан.

1. Татварын орлогын 4,528.9 мянган төгрөгийн замд яваа орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан байна.

Албан шаардлага:

1. Дэлгэрхаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь үндэслэлгүй шийдвэр гаргаж Аварга тохижилт ОНӨААТҮГ-ын удирдлагыг томилохыг Аварга багийн засаг даргад даалгасны дагуу Аварга багийн Засаг дарга нь Аварга тохижилт ОНӨААТҮГ-ын газрын даргыг үндэслэлгүй томилон ажиллуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.
2. Сумын төсвийн эх үүсвэрт урьд оны үлдэгдэл 33,972.0 мянган төгрөгийг бүрэн төлөвлөөгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын 2025 оны 8 дугаар сарын 11-ний 18 дугаар тогтоолоор баталсан төсвийн орлогын төлөвлөгөөнөөс малын тоо толгойн албан татварын орлогыг 26,032.5 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 6,520.0 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 5,760.3 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг 611.4 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 320.7 мянган төгрөгөөр, бууны албан татварын орлогыг 120.0 мянган төгрөгөөр буюу татварын орлогыг 39,364.9 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг 63,553.6 мянган төгрөгөөр, нийт 102,918.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн орлогыг орлогын төрөл бүрээр бүрэн төвлөрүүлж ажиллах

2. Авлагын үлдэгдлийг барагдуулахтай холбоотой асуудал

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн 52 зээлдэгчийн 238,798.6 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэл нь 100 хувь чанаргүй зээлийн ангилалд шилжсэнийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралт Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.4.5. “зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх” 7.3. “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтууд, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах ажлыг хууль тогтоомж, заавар журамд заасны дагуу барагдуулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	3,971.3			1	3,971.3	1	3,971.3				
ЗДТГ	1	62,584.8			1	62,584.8	1	62,584.8				
ИТХ	1	7,270.9			1	7,270.9	1	7,270.9				
ОНХС	1	22,857.3			1	22,857.3	1	22,857.3				
ОНХС	1	109,035.7	1	109,035.7			1	109,035.7				
ХХС	1	11,596.4			1	11,596.4		11,596.4				
ХХС	1	11,615.6			1	11,615.6		11,615.6				
Аварга тохижилт	1	328,011.1	1	328,011.1			1	328,011.1				
Аварга тохижилт	1	528.0	1	528.0			1	528.0				
Аварга тохижилт	1	9.2			1	9.2	1	9.2				

Аварга тохижилт	1	1,296.4			1	1,296.4	1	1,296.4				
Аварга тохижилт	1	6,993.0			1	6,993.0	1	6,993.0				
ОНТБ-ын дүн	12	565,769.7	3	437,574.8	9	128,194.9	10	565,769.7				
ТТЗ	1	4,528.9	1	4,528.9			1	4,528.9				
УТБ-ын дүн												
Дүн	13	570,298.6	4	442,103.7	9	128,194.9	11	570,298.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аварга тохижилт	1	440.0	1	440.0								
ИТХ	1	9,400.0			1	9,400.0						
ОНХС	1	29,054.0			1	29,054.0						
ОНТБ-ын дүн	3	38,894.0	1	440.0	2	38,454.0	0	0	0	0	0	0
ТТЗ	1	33,972.0			1	33,972.0						
ТТЗ	1	102,918.5			1	102,918.5						
ТТЗ	1	-			1	-						
ТТЗ	1	238,798.6				-	1	238,798.6				
ТТЗ-ийн дүн	2	238,798.6	0	0	1	0	1	238,798.6	0	0	0	0
Дүн	5	277,692.6	1	440.0	3	38,454.0	1	238,798.6	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0	0	0	0	0	00	



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 261-А2370447

Чингис хот

ХЭА-2026/018/НА-СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь 2025 оны төсвийг тодотгон батлуулахдаа орон нутгийн ерөнхий орлогын дансны эхний үлдэгдэл 33,972,028.00 (гучин гурван мянга есөн зуун далан хоёр мянга хорин найман) төгрөгийг бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.4. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Б.Энх-Амгаланд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 266-А23-70447 Чингис хот
ХЭА-2026/018/НА-СТА-ТТЗ

Г Зөрчлийг арилгах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дэлгэрхаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь үндэслэлгүй шийдвэр гаргаж Аварга тохижилт ОНӨААТҮГ-ын удирдлагыг томилохыг Аварга багийн засаг даргад даалгасны дагуу Аварга багийн Засаг дарга нь Аварга тохижилт ОНӨААТҮГ-ын газрын даргыг томилон ажиллуулсан байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.6. тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх, 35.1.15. Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 22. Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 2/ орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох; 18 дугаар зүйлийн 18.2.1-т "дээд боловсролтой", 18.2.2-т "аль нэг хуулийн этгээд буюу түүний салбар нэгжийн удирдах ажлыг 2-ос доошгүй жил хийсэн, удирдлагын зохиц дадлагатай;..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжид нийцээгүй шийдвэр гаргасан зөрчлийг арилган биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Л.Мөнхбат-д хариуцуулав.

2. ОНӨААТҮГ-ын удирдлагыг үндэслэлгүй томилсон зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Засаг дарга Б.Энх-Амгаланд хариуцуулав.
3. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Л.Мөнхбат, Засаг дарга Б.Энх-Амгалан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Н.ТУЯА